

Японы "CAL" компани Монголд оффисоо байгуулан, нээлтийн үдэшлэг зохион байгууллаа

eagle / Eaglenews / 2019-09-28 11:44:00 / 0



Япон улсын Осака хотод төв компани нь байрладаг "Кал" компани есдүгээр сарын 27-ны өдөр "Blue sky hotel"-д Монголын Улс төрийн албан тушаалтнууд, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулийн 250 орчим албан тушаалтнуудыг урьж компанийн нээлтийн үдэшлэг зохион байгууллаа.

CAL Co., Ltd нь Японд мэдээллийн технологи, механик төхөөрөмжийн зураг төсөл гэх мэт олон талт салбарт 1200 инженер ажиллуулдаг бөгөөд Toyota, Mitsubishi зэрэг компаниудын аутсорсинг ажлыг гүйцэтгэдэг бөгөөд Япон улсын Токио, Фукуока зэрэг 10 байршилд албан ёсны оффисуудтай. Түүнчлэн дөрвөн жилийн өмнө БНСУ-ын Сеул хотод гадаадаас ажилчин авах салбар байгуулснаар гадаад хүний нөөцийг идэвхтэй ажиллуулдаг Дэлхийн компани болж өссөн юм.

КАЛ ХХК нь есдүгээр сарын 27-нд Улаанбаатарт оффис байгуулан, Монголоос хүний нөөцийг ажилд авахтай холбогдуулан "Blue Sky" зочид буудалд зохион байгуулсан нээлтийн үйл ажиллагаа амжилттай боллоо. Нэмж хэлэхэд "Кал" ХХК-ийн Ерөнхий захирал ноён Ивасаки Хироши ярихдаа 10-р сарын 18,19-ны 2 өдөр "Сэрүүлэг" их сургууль болон Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төв дээр, компанийн танилцуулах өдөрлөг болно. Хэрэв та Япон улсад мэдээллийн технологийн чиглэлээр ажиллах хүсэл, сонирхолтой бол энэхүү үйл ажиллагаанд хүрэлцэн ирж, оролцохыг хүсэж байна гэж яриу.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

Утас: 95058611, 95058612, 95058613

Email:m-recruitment@cal.co.jp

http://Facebook: <https://www.facebook.com/cal.mongoliaoffice/>



Жиргээ

#eagle.mn Tweets

Сүүлд Их уншсан



Эсүүд хүчилтөрөгчийг мэдэрч дасдгийг судалсан эрдэмтэд Нобелийн
29 минутын өмнө



"Улаанбаатар" банкны барилга буюу Нийслэлийн захиргааны 4 дүгээр
1 цагийн өмнө



В.Путин төрсөн өдрөө тайгад самар, мөөг түүж тэмдэглэжээ
2 цагийн өмнө



"Joker" ашиг орлогоороо тэргүүлж байна
2 цагийн өмнө



"Ерөнхийлөгч хориг тавьснаар УХНӨ-ийн төслийг гацаасан юм биш"
3 цагийн өмнө



Э.Макрон: "Брексит"-ээр гэрээ хийх эсэхийг энэ долоо хоногийн сүүлээр
3 цагийн өмнө



Тендергүй 1.3 тэрбумаар үлээвэр хөгжим "шахсан" хэргийг АТГ шалгаж
3 цагийн өмнө

